



МОНГОЛ УЛС

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН

Т У Ш А А Л

2019 оны 06 дугаар сарын 04-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

Аргачлал, загвар батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 53.2, 54.2, 55.2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 36 дугаар тогтоолын 2, 37 дугаар тогтоолын 2, 38 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг 1 дүгээр хавсралт, Стратеги төлөвлөгөө, түүний хавсралтын загварыг 2 дугаар хавсралт, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний загварыг 3 дугаар хавсралт, Байгууллагын зохион байгуулалтын нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний загварыг 4 дүгээр хавсралт, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний загварыг 5 дугаар хавсралт, Стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах, үнэлэх аргачлалыг 6 дугаар хавсралт, Стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийн болон хавсралтын тайлангийн загварыг 7 дугаар хавсралт, Байгууллагын гүйцэтгэлийн тайлангийн загварыг 8 дугаар хавсралт, Байгууллагын зохион байгуулалтын нэгжийн гүйцэтгэлийн тайлангийн загварыг 9 дүгээр хавсралт, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн тайлангийн загварыг 10 дугаар хавсралт, Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний хуудасны загварыг 11 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тушаалын 1-д заасан аргачлал, загварыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг бүх шатны төсвийн шууд захирагч, төрийн жинхэнэ албан хаагч нарт үүрэг болгосугай.

3. Аргачлал, загварыг төрийн байгууллага, төрийн жинхэнэ албан хаагчдын үйл ажиллагаанд мөрдүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газар (Э.Бат-идэр)-т үүрэг болгосугай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

0000130